



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 01 сарын 13 өдөр

Дугаар 08/09

Мандалговь

**“Аймгийн төвийн Нэгдсэн эмнэлэгт Автоклаб”
нийлүүлэгчийг сонгон шалгаруулах
үнэлгээний хороо байгуулах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Аймгийн төвийн Нэгдсэн эмнэлэгт Автоклаб” нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: А.Нарантуяа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Гишүүд: Ц.Эрдэнээ (Иргэний төлөөлөл)
О.Мөнгөнхундага (Нэгдсэн эмнэлэг Тоног төхөөрөмжийн нярав)

Нарийн бичгийн дарга: А.Үүрийнцолмон (Нэгдсэн эмнэлэг эм зүйч)
Б.Адъяасүрэн (Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн)

Хоёр. Тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хорооны дарга (А.Нарантуяа)-д даалгасугай.

Гурав. Тендер шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Б.Адъяасүрэн)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ЭРДЭНЭСҮРЭН

482060016